



Захирлын 2019 оны.....дугаар сарын.....-ны

өдрийн.....дугаар тушаалын хавсралт

МУИС-ИЙН ХАРЬЯА БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ АХЛАХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей ахлах сургуулийн байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай 10 дугаар ангид нийслэл хот болон хөдөө орон нутгаас 2019-2020 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг баримтална.

2. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

3. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр хүсэлт гаргасан суралцагчийг "бүртгүүлэгч", зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг "элсэлтийн комисс", "элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг "комиссын гишүүн" гэнэ.

4. Байгаль-Эх лицей ахлах сургуульд суралцагч элсүүлэх ажлыг МУИС-ийн захирлын тушаалаар томилсон комисс зохион байгуулна.

5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.

6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://www.num.edu.mn>, <http://eecbehs.num.edu.mn> цахим хуудсанд байрлуулна.

7. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулсан элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

8. Элсэлтийн шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сэдэв боловсруулах, шалгалтын хугацаа ба үнэлгээний шалгуур тогтоох, нууцлал хадгалах зэрэг асуудлыг элсэлтийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, комиссын гишүүд хариуцна.

9. Тус сургуульд элсэхийг хүссэн, 9 дүгээр анги төгсөж байгаа суралцагчдыг бүртгэнэ.

10. Нийт бүртгүүлэгчдээс математик болон санал өгсөн судлагдахууны дагуу байгалийн ухааны физик, хими, биологи, газарзүйн шалгалтыг тус тус авна. Шалгалтын материал холимог бүтэцтэй үүнд: 70% нь тест, 30% нь уламжлалт бодох даалгавар байна. Онооны жагсаалтыг математик, математик физик, математик-хими, математик-биологи, математик-газарзүй (математик-40%, байгалын ухааны шалгалтын оноо 60%) гэж гарган, гүнзгийрүүлэн судлах чиглэлийн бүлэг тус бүрээр зохих хяналтын тоонд багтааж элсүүлнэ.

11. Улс, аймаг, нийслэл, дүүргийн төрөлжсөн олимпиадын математик, байгалийн ухааны хичээлийн төрөлд оролцож медальт болон шагналт байр эзэлсэн суралцагчдыг хяналтын тоонд багтаан шалгалтгүй элсүүлнэ.

12. Элсэгчдийн сургалтын төлбөрийг дараах байдлаар хөнгөлнө. Үүнд:

- Улсын төрөлжсөн олимпиадын математик, байгалийн ухааны хичээлийн төрөлд эхний 3 байр эзэлсэн суралцагчдын эхний жилийн сургалтын төлбөрийг 100 хувь,

- Аймгийн төрөлжсөн олимпиадын математик, байгалийн ухааны хичээлийн төрөлд эхний 3 байр эзэлсэн суралцагчдын эхний жилийн сургалтын төлбөрийн 50 хувь, дотуур байрны төлбөрийн 50 хувь,

- Нийслэл, дүүргийн төрөлжсөн олимпиадын математик, байгалийн ухааны хичээлийн төрөлд эхний 3 байр эзэлсэн суралцагчдын эхний жилийн сургалтын төлбөрийн зохих хувь,

13. Урилгаар элсэн суралцах элсэгчид элсэлтийн шалгалтаас өмнө 06 дугаар сарын 07-ны дотор сургалтын төлбөрийн 50 хувийг төлж элсэлтийг баталгаажуулна. Баталгаажсан орон тоог хүчингүй болгож элсэлтийн тоонд өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт сургалтын төлбөрийн 5 хувийн суутгалыг сургуульд төлнө.

14. Элсэх болзол хангаж, хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчдийг заасан хугацаанд бүртгэж, элсэх эрх олгоно. Бүртгүүлэгч элсэх эрх авахдаа дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Төрсний гэрчилгээний хуулбар
- Суурь боловсролын гэрчилгээ
- Хувийн хэрэг /шилжүүлсэн байх/
- Сургалтын төлбөр төлсөн баримт

15. Зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчийг тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэн, дараа өдрийн 10:00 цагаар тасалбар болгон онооны дарааллаар дараагийн шалгуулагчид элсэх эрхийг шилжүүлнэ.

16. Тухайн элсэгчийн сонгосон бүлгээс өөр бүлэгт шилжүүлэн элсүүлэхгүй ба элсэлтийн эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.